



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/629

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 3.4.3.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн политехникийн коллежийн багш, ажилтнуудын дунд зохион байгуулагдах урлагийн наадмыг зохион байгуулах арга хэмжээний зардалд 600000 (зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 600000 (зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101175